

## **СХЗГ-ЫН ХЭЛТЭС АЛБАДЫН 2014 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ТОВЧ ТАЙЛАН.**

### **1. Хэмжил зүйн бодлого, эталоны хэлтсийн 2014 оны үйл ажиллагааны жилийн эцсийн товч тайлан**

#### **Нэг. Хэмжил зүйн хууль эрх зүйг бүрдүүлэх, бодлого, стратеги тодорхойлох үйл ажиллагааны хүрээнд:**

1/ Ажлын хэсэг “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль”-ийг шинэчлэх үзэл баримтлалын болон энэ хуулийн анхны төслийг боловсруулан Шадар сайдын ажлын албанд хүргүүлж, ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу хэмжил зүйн үйл ажиллагааны олон улсын тогтолцоо, хөгжлийн хэтийн хандлагатай уялдуулан дахин хянан сайжруулж, хуулийн үзэл баримтлалын төслийг 7 дугаар сард багтаан Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

2/ Байгууллагын хэмжээнд ISO 9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Хэмжил зүйн бодлого, эталоны хэлтсийн “Чанарын гарын авлага”, техникийн журмын төслүүдийг боловсруулан, Ажлын хэсгийн саналыг авч, сайжруулалт хийж байна.

3/ Хүн амын оношлогоо, эмчилгээнд ашиглаж буй даралтын аппарат, төрөл бүрийн халууны шилээс эхлээд температур, даралтын бүх хэмжих хэрэгслийг шалгалт тохируулга, баталгаажуулалтад өргөн хүрээтэй хамруулж байна. ЭМЯ-ны харъяа “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохиргоо, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэлийн тогтолцоо хариуцсан нэгж”-ийг 2014 онд бий болгохоор ЭМЯ-тай хамтран ажиллаж, хэмжил зүйн мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

4/ ХБНГУ-аас хэрэгжүүлж буй “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга”, “Эрчим хүчний чанарын дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” төслүүдийн хүрээнд:

а/ “Монгол Улсын хэмжил зүйн салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх стратеги”-ийн төслийг боловсруулах чиглэлээр ХБНГУ-ын Физик Техникийн Хүрээлэн (РТВ)-тэй хамтран ажиллаж байна. Энэ ажлыг хамтын ажиллагааны цаашдын чиглэлийн хүрээнд РТВ-ийн талд хүсэлт болгон тавих саналтай.

б/ “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” төслийн хүрээнд тус газрын Температурын эталон лабораторид Олон улсын температурын хуваарийн “Усны гурвалсан цэгийн эталон”, мөн өндөр нарийвчлалын хоёрдогч хэмжүүрийг бий болгосноор (0÷1100)°С-ийн хэмжлийн хязгаарт бүх төрлийн термопарт шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэх боломжийг бүрдүүлж температурын хэмжлийн төрлөөр олон улсын болон бүс нутгийн лаборатори хоорондын харьцуулалтанд оролцох бүрэн боломжтой болж чадавхиа нэмэгдүүллээ.

5/ БНЧУ-ын Стандарт, хэмжил зүйн хүрээлэнгээс Монгол Улсын “Цаг, давтамжийн эталоны нарийвчлалыг дээшлүүлэх” төслийг хэрэгжүүлэн, цаг, давтамжийн эталоны нарийвчлалын түвшинг 10 дахин нэмэгдүүлж эталоны тогтолцоог боловсронгуй болгож, үндэсний цагийн хуваарь UTC(MASM) –ийг Олон улсын цагийн хуваариас  $\pm 50$  наносекундээс ихгүй зөрүүтэй гаргаж хадгалан, Дэлхийн цагийг гаргадаг Олон улсын зохицуулсан цаг (UTC)–ийг гаргахад Монгол Улсын цаг, давтамжийн эталон лаборатори өөрийн хувь нэмрээ оруулах боломж бүрдлээ. Цагийн нэгж секунд, үндэсний цагийн хуваарийг гаргаж хадгалан сүлжээний цагийн серверээр дамжуулан хэрэглэгчдэд түгээж байна.

6/ Массын эталон лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хэмжлийн чадавхи (СМС)-ийг Ази, Номхон далайн Хэмжил зүйн Хөтөлбөр (АРМР) -ийн холбогдох техникийн хороодоор дамжуулан Жин ба Хэмжүүрийн Олон улсын Товчооны харьцуулалтын өгөгдлийн сан (BIPM/CDB)-д оруулахад шаардагдах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

7/ Хэмжил зүйн зөвлөл нь 2014 оны эхний хагас жилд 4 удаа хуралдаж, хэмжих хэрэгслийн загварын туршилтаар 43 хэмжих хэрэгслийн загварыг шинээр туршилтад хамруулан, Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн хэмжих хэрэгслийн загварын гэрчилгээ олгож, манай улсын хэмжүүрийн паркыг шинэчлэх нөхцлийг бүрдүүлэн ажиллаа. Загварын туршилтаар 6.5 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн тоо, орлогын төлөвлөгөөг биелүүлжээ. Мөн Геологийн төв лабораторийн зохион бүтээсэн, “Манган нодулын CGL 131 аттестатчилсан стандартчилсан загвар”-ыг Монгол Улсын стандартчилсан загвараар батлуулсан байна.

8/ Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, засвар, суурилуулалт, худалдаа эрхлэх хэмжил зүйн ажил, үйлчилгээний тусгай зөвшөөрлөөр хүсэлт гаргасан 27 аж ахуйн нэгж, байгууллагын асуудлыг шийдвэрлүүлж, 5.8 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

### **ХОЁР. Эталоны харьцуулалт, шалгалт тохируулгын үйл ажиллагаа**

9/ Цахилгааны эталон лаборатори улсын болон анхдагч эталонуудаа гадаад харьцуулалтад хамруулах талаар судалгаа хийж, 2014 оны 3 дугаар улиралд БНЧУ-ын KRISS-д хийлгэхээр мэргэжилтнүүдийн хэмжээнд тохирсон байна. Үүнийг манай хэлтэс, гадаад харилцааны асуудал хариуцсан нэгж, газрын даргын хэмжээнд хэлэлцэн шийдвэр гаргана. Мөн тус лаборатори Европ, Азийн бүс нутгийн хэмжил зүйн байгууллага /COOMET/ -ын хүрээнд Гүрж Улсын хэмжил зүйн байгууллагаас зохион байгуулах тогтмол гүйдлийн эсэргүүцлийн 100 Ом, 100 кОм харьцуулалтад оролцохоор төлөвлөн ажиллаж байна.

10/ Тус хэлтсийн эталон лабораториуд санхүүтэй нийлснээр 600 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын 2,9 мянган ширхэг эталон болон өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгсэлд нэгж дамжуулалт, шалгалт тохируулгыг гүйцэтгэж, 51.8 сая төгрөгийн орлоготой ажиллан орлогын төлөвлөгөөг 195.0 хувиар биелүүллээ.

## ХЭМЖИЛ ЗҮЙН БОДЛОГО, ЭТАЛОНЫ ХЭЛТЭС

### 2. Итгэмжлэлийн хэлтсийн 2014 оны жилийн эцсийн ажлын товч тайлан

Итгэмжлэлийн хэлтэс нь тайлант хугацаанд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:

#### **Итгэмжлэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр**

1. Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-ын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (MRA)-ийн таних тэмдгийг үндэсний итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдгийн хамт хэрэглэх зөвшөөрөл, лицензийн гэрээнд СХЗГ-ын дарга 2014 оны 4 сарын 04-ний өдөр гэрээнд гарын үсэг зурсан. Ингэснээр үндэсний итгэмжлэгдсэн лабораториуд нь ILAC-ын ХХЗХ-ийн тэмдгийг үндэсний итгэмжлэлийн таних тэмдэгтэй хослуулан хэрэглэх эрхтэй боллоо. 2014 оны 06 сарын 06-нд Геологийн төв лаборатори нь үндэсний итгэмжлэлийн тогтолцооны таних тэмдгийн хамт ILAC MRA таних тэмдгийг ашиглах гэрээнд гарын үсэг зурсан анхны лаборатори болоод байна.

Үндэсний итгэмжлэгдсэн лабораториуд энэхүү тэмдгийг хэрэглэснээр үр дүн нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх, ингэснээр худалдаан дах саад тотгорыг арилгах, үйлдвэрлэл, бизнесийг дэмжих ач холбогдолтой болсон талаархи мэдээллийг бэлтгэн, “Зууны мэдээ” сонин, (2014.04.29-ний дугаар), байгууллагын цахим хуудсаар мэдээлж ажиллаж байна.

2. Заавал итгэмжлэлд хамрагдах тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг Шадар сайд, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 10/50 дугаар тушаалаар батлууллаа. Энэхүү төлбөрийн хэмжээг 2014 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөж эхлэхтэй холбогдуулсан зохицуулалтыг СХЗГ-ын даргын 2014 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/104 тоот тушаалаар батлуулаад байна.

#### **Үндэсний мэргэжилтнүүдийг чадавхижуулах чиглэлээр**

1. Итгэмжлэлийн байгууллагын ажилтнуудын чадавхийг сайжруулах асуудлаар тус хэлтэс нь ГХСМА-тай хамтран итгэмжлэлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд:

- PAC (Номхон далайн бүсийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага)-аас Тайланд улсад зохион байгуулсан ижил түвшний үнэлгээний мэргэжилтэн бэлтгэх сургалтанд ИХ-ийн 2 ажилтан;
- PAC/APLAC/PTB-ээс Сингапур улсад зохион байгуулсан ISO/IEC 17065 стандартын 4 өдрийн сургалтанд ИХ-ийн 2 ажилтан тус тус хамрагдсан.

2. Тохирлын үнэлгээний байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтыг нийт 4 удаа зохион байгуулан явууллаа. Үүнд:

- ISO 15189:2012 стандартын 2 өдрийн сургалтанд эмнэлгийн лабораторийн 14 ажилтан;
- MNS ISO/IEC 17025:2007 стандартын 3 өдрийн сургалтанд 42 ажилтан;
- MNS ISO/IEC 17065:2013 стандартын 5 өдрийн сургалтанд 65 ажилтан;
- MNS ISO/IEC 17025:2007 ба дотоод аудит явуулах аргагүй 2 өдрийн сургалтанд 45 ажилтан тус тус хамрагдсан.

### **Тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн чиглэлээр**

1. Итгэмжлэлийн удирдах зөвлөлийн хурлыг 5 удаа зохион байгуулан хуралдуулсан, нийт 39 тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна. Үүнд: шинээр итгэмжлэгдсэн 12, дахин үнэлгээнд хамрагдан итгэмжлэгдсэн 22, итгэмжлэлийн хүрээг өргөтгөн итгэмжлэгдсэн 5 байгууллага байна.

2. Нүүрсний шинжилгээний ур чадварын сорилт хөтөлбөрийг эрдсийн шинжилгээний ажлын болон стандартчилсан загвар үйлдвэрлэлийн олон жилийн туршлагатай Геологийн төв лабораторитой хамтран зохион байгуулж байна. Энэ нь эрдсийн шинжилгээний лабораториудын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнгийн чанар, үнэмшилт магадлалыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

### **ЗГ-ын 2002 оны 265 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр**

1. Шинжилгээний уур чадварын бүдүүвчид оролцох лабораторийн нэр, тоо ба 2014 оны хөтөлбөрийг боловсруулсан. Үүний дагуу 2014 оны 1-р ээлжийн Ур чадварын сорилтыг МХЕГ-ын Үндэсний лавлагаа лабораторитай хамтран явууллаа.

### **Итгэмжлэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгон хөгжүүлэх чиглэлээр**

1. ISO/IEC 17024:2012 “Тохирлын үнэлгээ-Ажилтны баталгаажуулалтыг хэрэгжүүлэх байгууллагад тавих ерөнхий шаардлага” стандартыг орчуулан үндэсний стандартаар батлуулаад байна.

2. БНХАУ, БНТУ-ын Итгэмжлэлийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө, саналын төслийг боловсруулаад байна.

3. ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу Итгэмжлэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх менежментийн тогтолцооны баримт бичиг болон ЧГА холбогдох дүрэм, журамд дахин үзлэг явуулж, байнгын сайжруулалт хийх шаардлагын дагуу 4 журмыг дахин хянаж, нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна.

4. Дэлхийн итгэмжлэлийн өдөр 2014 –ийг тохиолдуулж “Итгэмжлэл-эрчим хүчний тогтолцоонд итгэлцлэлийг бий болгоно” сэдэвт семинар хэлэлцүүлгийг 2014.06.06-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Тус семинарт гадны аж ахуйн нэгж байгууллагын 100 гаруй төлөөлөл болон газрын албан хаагчид, тус хэлтэст ажиллаж байсан ахмадууд хамрагдлаа. Мөн Стандарт хэмжил зүй сэтгүүлийн тусгай дугаарыг хэлтсийн зүгээс эрхлэн гаргаж, семинарт тавигдсан илтгэлүүдийг сэтгүүл байдлаар хэвлэн гаргаж оролцогчдод тараасан. Семинарын үеэр “Стандартчилал, хэмжилзүйн тэргүүний ажилчин” тэмдгээр 5, Салбарын Жуух бичгээр 7 хүн шагнагдсан байна.

5. 2014 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжиж буй “Монгол улсын стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх” Европын холбооны төслийн багт итгэмжлэлийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид тавих зорилт, хэрэгжүүлэх

арга замын талаар өөрсдийн саналыг танилцуулан, хамтран ажиллаж байна. Тус төслийн багийн төлөвлөгөөнд итгэмжлэлийн асуудлаар хамтран ажиллах чиглэл, хугацааны талаар саналаа хүргүүлэн ажиллаж байна.

### **Бусад ажил**

1. Тус хэлтэс нь 2014.03.23-ны өдөр байгууллагын ажилтнуудын сагсан бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд эрэгтэй 7, эмэгтэй 4 баг оролцсон. Тэмцээний эрэгтэй 1-р байрт ТЗУХ-ийн баг, эмэгтэй 1-р байрт Итгэмжлэлийн хэлтэс, СХХ, ХШҮА-ны албаны холимог баг тэргүүлсэн. Мөн Сорьцын хяналтын хэлтсээс зохион байгуулсан Снукер биллъярдын тэмцээнд хэлтсийн тамирчид болон хөгжөөн дэмжигчид идэвхтэй оролцсон.
2. Монгол улсын “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 14 дүгээр тушаалын 3 дахь заалтыг үндэслэн СХЗГ, МХЕГ-ын 137/А-99 хамтарсан Ажлын хэсэг батлах тушаалын дагуу Итгэмжлэлийн хэлтсийн Ур чадварын сорилтын химийн 13, нян судлалын лабораторийн 18 тоног төхөөрөмжийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторид хүлээлгэн өгсөн. Лабораторийн 2 ажилтны орон тоо, цалингийн санг шилжүүлэх талаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлээд байна.
3. Итгэмжлэлийн орлого 36,620 сая төгрөг, ур чадварын сорилтын лабораторийн орлого 5,170 сая төгрөг байна.

## ИТГЭМЖЛЭЛИЙН ХЭЛТЭС

### **Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн 2014 оны жилийн эцсийн үйл ажиллагааны товч тайлан**

Стандартчиллын Үндэсний Зөвлөл (СҮЗ) нь төрийн болон төрийн бус, шинжлэх ухааны холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллөөс бүрдэх орон тооны бус, 20 гишүүнтэй. Үндэсний стандарт, стандартчиллын хөтөлбөрийг батлах, хүчингүй болгох, хууль тогтоомжид нийцүүлэн стандартчилал, тохирлын үнэлгээний ажлын хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлох, стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбогдсон дүрэм, журам, зааврыг батлах, стандартчиллын техникийн хороодыг байгуулах, тэдгээрийн дүрмийг батлах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

СҮЗ –ийн бүрэлдэхүүнийг 2012 оны 11 дүгээр сард Монгол Улсын Засгийн Газрын 42 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулсан.

СҮЗ -ийн үйл ажиллагааны тайланг 2014 оны 06 дугаар сарын байдлаар доорх чиглэлээр товч танилцуулж байна. Үүнд:

1. Баталсан стандартын талаар:

2014 оны хагас жилийн байдлаар СҮЗ нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хуурамч бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2, 4, 5 саруудад нийт 3 удаа хуралдаж 90 үндэсний стандарт хэлэлцсэн байна. Тайлант хугацаанд Стандартчиллын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар нийт 90 стандартыг хэлэлцэн баталсанаас 88 стандартыг үндэсний стандартаар батлан, 1 стандартыг эрх зүйн хэм, хэмжээг өөрчиллөө. Тайлант хугацааны хуралдаанд шинээр -28, дахин хянасан-15, үндэсний болгох-45 стандартыг авч хэлэлцсэн байна. /Дэлгэрэнгүй товъёогийг техникийн хороо болон техникийн хорооны нарийн бичгийн дарга нарын төлөвлөгөөнд тусгасан үүнээс биелүүлсэн хүснэгтээр харуулав./

## 2. Батлагдсан стандартуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал

Стандартчиллын үндэсний зөвлөлийн сар бүрийн хуралдаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг тогтмол авчран сурталчуулж байсан. Мөн сар бүрийн хуралдааны мэдээлэл болон батлагдсан стандартуудыг хэвлэл мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөнд тусган вэб сайт болон сонин хэвлэлээр сурталчилсан. “Стандарт хэмжилзүй” сэтгүүлд Стандартчиллын үндэсний зөвлөлийн талаарх мэдээлэл гаргасан.

### Техникийн хорооны стандартчиллын 2014 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийн байдал, тоогоор

д/д	Техникийн хороо болон дэд хороо	Стандартчиллын 2014 оны ажлын төлөвлөгөөнд туссан	Шинээр боловсруулах	Дахин хянасан	Үндэсний болгох	Батлагдсан	Шинээр боловсруулах	Дахин хянасан	Үндэсний болгох
1	Тохирлын үнэлгээний стандартчиллын техникийн хороо ТХ 01	7	-	-	7	-	-	-	-
2	Чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001)-ны стандартчиллын техникийн хороо	2	-	-	2	1 (50%)	-	-	1

	ТХ 02								
3	Байгаль орчны удирдлагын тогтолцоо (ISO 14000)-ны стандартчиллын техникийн хороо ТХ 03	4	-	-	7	-	-	-	-
4	Банк, санхүү, даатгалын стандартчиллын техникийн хороо ТХ 04	1	1	-	-	-	-	-	-
5	Нягтлан бодох бүртгэлийн стандартчиллын дэд хороо ТХ 04/ДХ 01	4	-	-	4	4 (100%)	-	-	-
6	Нэр томъёоны стандартчиллын техникийн хороо ТХ 05	-	-	-	-	-	-	-	-
7	Эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн стандартчиллын техникийн хороо ТХ 06	13	11	2	-	8 (61,5%)	7	1	-
8	Байгаль орчны стандартчиллын техникийн хороо ТХ 07	23	13	5	5	8 (34,7%)	4	4	-
9	Аялал жуулчлалын	4	2	2	-	-	-	-	-

	стандартчиллын дэд хороо ТХ 07/ ДХ 01								
10	Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хороо ТХ 08	5	3	-	2	6 (120,4%)	3	-	3
11	Хэмжил зүйн стандартчиллын техникийн хороо ТХ 09	14	-	3	11	7 (50 %)	1	2	4
12	Сорилтын стандартчиллын дэд хороо ТХ 09/ ДХ 01	-	-	-	-	-	-	-	-
13	Механик, үйлдвэрлэлийн техник хэрэгслийн стандартчиллын техникийн хороо ТХ 10	18	-	-	18	1 (5,5%)	-	-	1
14	Эрчим хүчний стандартчиллын техникийн хороо ТХ 11	10	-	-	10	-	-	-	-
15	Цахилгаан техник, электрон барааны стандартчиллын техникийн хороо ТХ 12	-	-	-	-	-	-	-	-

16	Мэдээлэл, харилцаа холбооны стандартчиллын техникийн хороо ТХ 13	12	9	1	2	-	-	-	-
17	Баримт бичгийн стандартчиллын техникийн хороо ТХ 14	2	-	2	-	-	-	-	-
18	Автозамын стандартчиллын техникийн хороо ТХ 15	12	5	2	5	17 (141,6 %)	3	6	8
19	Автотээврийн стандартчиллын техникийн хороо ТХ 15/01	22	1	5	16	17 (77,2 %)	1	-	16
20	Ноос, ноолуурын стандартчиллын техникийн хороо ТХ 16	12	3	-	9	-	-	-	-
21	Арьс ширний стандартчиллын дэд хороо ТХ 16/ ДХ 01	13	-	13	-	-	-	-	-
22	Оёмол бүтээгдэхүүний стандартчиллын дэд хороо ТХ 16/ ДХ 02	7	2	1	4	2 (28,5 %)	-	-	2
23	Хөдөө аж ахуйн стандартчиллын техникийн хороо	10	4	4	2	3 (30,0%)	3	-	-

	ТХ 17								
24	Газар тариалангийн стандартчиллын дэд хороо ТХ 17/ДХ 01	18	3	-	15	-	-	-	-
25	Мал аж ахуйн стандартчиллын дэд хороо ТХ 17/ДХ 02	7	7	-	-	-	-	-	-
26	Хүнсний стандартчиллын техникийн хороо ТХ 18	6	-	-	6	-	-	-	-
27	Ургамлын гаралтай хүнсний стандартчиллын дэд хороо ТХ 18/ДХ 01	13	2	1	10	-	-	-	-
28	Амьтны гаралтай хүнсний стандартчиллын дэд хороо ТХ 18/ДХ 02	7	1	-	6	-	-	-	-
29	Хими, химийн технологийн стандартчиллын техникийн хороо ТХ 19	2	1	-	1	2 (100%)	-	-	2
30	Уул уурхай, ашигт малтмалын стандартчиллын техникийн хороо	14	-	-	14	4 (28,5%)	2	-	2

	ТХ 20								
31	Төмөрлөгийн стандартчиллын техникийн хороо ТХ 21	5	-	3	2	-	-	-	-
32	Барилгын стандартчиллын техникийн хороо ТХ 22	16	4	2	10	-	-	-	-
33	Ой, модын стандартчиллын техникийн хороо ТХ 23	13	13	-	-	1 (7,6%)	1	-	-
34	Үйлчилгээний стандартчиллын техникийн хороо ТХ 24	2	1	1	-	1 (50 %)	1	--	-
35	Боловсролын стандартчиллын дэд хороо ТХ 24/ ДХ 01	2	2	-	-	-	-	-	-
36	Биеийн тамир, спортын стандартчиллын дэд хороо ТХ 24/ ДХ 02	2	2	-	-	-	-	-	-
37	Газрын тос, байгалийн хийн стандартчиллын техникийн хороо ТХ 25	13	4	1	8	-	-	-	-
38	Төрийн үйлчилгээний стандартчиллын	2	-	-	2	-	-	-	-

	техникийн хороо ТХ 26								
39	Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний стандартчиллын техникийн хороо ТХ 27	15	7	2	6	1 (6,6%)	-	1	-
40	Гоо сайханы стандартчиллын техникийн хороо ТХ 28	-	-	-	-	-	-	-	-
41	Сав баглаа боодлын стандартчиллын техникийн хороо ТХ 29	-	-	-	-	-	-	-	-
42	Шил, хуванцар, цаасны стандартчиллын техникийн хороо ТХ 30	-	-	-	-	-	-	-	-
43	Худалдаа, нийтийн хоолны стандартчиллын техникийн хороо ТХ 31	2	1	1	-	1 (50 %)	-	-	1
44	Нанотехнологийн стандартчиллын техникийн хороо ТХ 32	4	-	-	4	1 (25%)	-	-	1
45	Төмөр зам, далай	36	25	-	11	6	6	-	-

	ашиглалт ба усан замын тээврийн стандартчиллын техникийн хороо ТХ 33					(16,6%)			
46	Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хороо ТХ 34	1	-	-	1	-	-	-	-
47	Соел урлагийн стандартчиллын техникийн хороо	1	1	-	-	-	-	-	-
48	Газрын салбарын стандартчиллын техникийн хороо ТХ 13	-	-	-	-	1 (100%)	-	1	-

## СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС

### Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын хэлтсийн 2014 оны бүтэн жилийн ажлын тайлан

Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын хэлтэс нь Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, “Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам” болон бусад хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийг баталгаажуулж, буруу хэмжлийн сөрөг үр дагавараас хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 3 дугаар сар 12-ны өдрийн 14 тоот тушаалын дагуу Засгийн газрын тохируулагч агентлаг, Стандартчилал, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн өөрчилсөнтэй холбоотойгоор 2014 оны 1 дүгээр улиралд Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын албаны, 2 дугаар улирлаас Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын хэлтсийн зохион байгуулалтаар хэлтсийн дарга-1, ахлах мэргэжилтэн-4, улсын шалгагч-15, хэмжүүрийн техникч-4, хэмжүүр хүлээн авагч-1, нийт 27 оронтойгоор ажилласан болно.

#### 1. Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын тоо, орлогын гүйцэтгэлийн талаар:

“Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам” -ын 3 дугаар зүйлийг үндэслэн 2014 оны хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийх гэрээг 102 аж ахуйн нэгж, байгуулагуудтай байгуулан, эдгээр гэрээний дагуу боловсруулсан график-төлөвлөгөөг үндэслэн хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын ажлыг хэмжүүрийн улсын шалгагчид хэрэгжүүллээ.

Хэлтэс, лаборатори бүрийн 2014 оны эхний хагас жилд шалгаж баталгаажуулах хэмжих хэрэгслийн тоо, орлогын төлөвлөгөөг ажилтнуудад жигд хуваарилан хариуцуулж дүүрэг, аж ахуйн нэгж, байгуулагуудад ашиглагдаж байгаа хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыг ээлжит болон дуудлагаар хийж гүйцэтгэжээ.

Хэмжил зүйн хяналт шалгалтын ажлын томоохон хэлбэр болох хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын ажлын хүрээнд 2014 оны эхний хагаст **40** орчим нэр төрлийн **45830** ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулан **264,6** сая төгрөгийн орлоготой ажиллахаас **107440** ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулан **772,1** сая төгрөгийг оруулж, тооны төлөвлөгөөг **234,4** %, орлогын төлөвлөгөөг хийсэн ажлын гүйцэтгэлээр **291,8** %-иар биелүүлсэн.

Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлын тоо, орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр гаргаж тайланд хавсаргав.

## **2. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлын зохион байгуулалт, ажилтнуудын үр дүнгийн гэрээний талаар:**

Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын лаборатори(ХХШБЛ)–иудын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ХХШБЛ-иудын ахлах мэргэжилтэн, хэмжүүрийн улсын шалгагчдын 2014 оны үр дүнгийн гэрээг боловсруулан 4 сард шинэчлэн батлуулсан.

ХХШБЛ-иудын хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын тоо, орлогын төлөвлөгөөг хүн нэг бүрээр батлуулан гүйцэтгэлийг сар бүр гаргаж ТЗУГ-т мэдээлж байна. Түүнчлэн хэмжих хэрэгслийн баталгаажуулалт болон шалгалт тохируулгын үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэт цаасны тооцоог улсын шалгагч, лаборатори тус бүр бүрээр гаргуулан санхүүтэй нийлж хяналт тавин ажиллаж байна.

2014 оныг сахилга хариуцлагын жил болгон зарласантай уялдуулан лабораторийн улсын шалгагчдын сар бүр томилолтоор ажиллах хуваарийг тогтмол гарган цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд А.Ганболд, Зэсмаа, Баяржаргал, Сүхбаатар нарын 4 ажилтан хэмжүүрийн улсын шалгагчийн эрхийг шинээр болон сэргээн авлаа. Мөн Авилгын эсрэг хуулийн 10 дугаар зүйл, УИХ-ын 2007 оны 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу албаны бүх төрийн албан хаагч нар хөрөнгө, орлогын болон сонирхолын зөрчлийн тухай мэдүүлгээ хуулийн хугацаанд багтаан гаргаж албажуулсан.

Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажилд хэрэглэгдэх шалгалтын протокол, гэрчилгээ, маягт, бүртгэлийн журнал зэрэг шаардлагатай материалыг захиалж хийлгэх ажлыг ТЗУГ-тай хамтран шийдвэрлэж 2014 оны хэрэгцээт бүрэн хангасан.

Даралт, температур болон эрүүл мэндийн салбарын хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажлын зохин байгуулалтын талаарх саналыг боловсруулсан ХХШБХ-ийн даргад 2014 оны 05 дугаар сард танилцуулсан.

СХЗГ-ын даргын 2013 оны А/357 дугаар тушаалаар баталсан СХЗГ-т Чанарын удирдлагын тогтолцоог ISO 9001:2008 стандартын дагуу нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ХХШБХ-т ISO 9001:2008 стандартыг нэвтрүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлж байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай хамтран ажиллах санамж бичгийг боловсруулан 2 байгууллагын даргаар 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлуулсан бөгөөд санамж бичгийн хавсралтанд заагдсан ажлын төлөвлөгөөний дагуу холбогдох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- УБЦТС ТӨХК-ийн лабораторийн хүчин чадалд үндэслэн улсын шалгагч нарын ажлыг жигд хувиарилан томилон ажиллуулах;
- Түүвэр баталгаажуулалт хийлгэх талаар түгээх компанид зааварчилгаа өгсөн бөгөөд хийгдэх ажлын шат дарааллыг тухай бүр төлөвлөн зохион байгуулан ажиллах;
- Түүвэр баталгаажуулалтын гэрчилгээг сайн чанарын зузаан цаасан дээр хэвлэх чадвартай принтерийн судалгааг гарган санхүүд өгөх;
- Улсын баталгаажуулалтын гэрчилгээний нөөцийг 1 сараас доошгүйг бэлдэн тасалдалгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- Улсын шалгагчдыг хар тугалны хордлогоос бага ч бол уу сэргийлэх үүднээс амны хаалт, бээлийний нэхэмжлэхийг байгууллагын санхүүд өгч шийдвэрлүүлсэн;
- Цохиж дардам гаргах зориулалт бүхий гадсан лацыг цаашид цахилгаан хэмжих хэрэгсэлд ашиглахыг зогсоох тухай судалгаа дүгнэлтийг Хэлтсийн даргад 2014 оны 4 сард даргын зөвлөлт танилцуулан шийдвэрлүүлэхээр тус тус өгөн ажиллаж байна.

### **3. Хууль, дүрэм журмын төсөл, стандарт, НТББ-ын боловсруулалтын талаар:**

Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 87 дугаар тушаалаар баталсан Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэгт тус хэлтсийн дарын үүргийг орлог гүйцэтгэгч З.Ганболд, ахлах мэргжилтэн А.Ганболд нар орж ажиллан хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн шинэчлэсэн найруулга, Хэмжил зүйн тухай хуулийн үзэл баримтлал, анхны төслийг боловсруулан Шадар сайдын албанд хүргүүлээ.

“Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам”, “Хэмжүүрийн улсын шалгагчийн эрх олгох, түүнийг аттестатчилах журам”-уудыг СХЗГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж албажуулан орон нутгийн саобаруудад хүргэх ажлыг зохион байгуулсан.

ХХШБХ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан Цахилгаан механик болон электрон тоолуурын импульсийн гаралтын төхөөрөмж IEC 62053-31 стандартыг орчуулж дуусган бөгөөд хэмжилзүйн стандартчилалын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр стандартын хэлтсийн мэргэжилтэн Б.Ундраад өгөөд байна. Шинээр гүйдлийн трансформаторын загварын туршилтын IEC 60044-1 стандартыг орчуулах ажлыг эхлүүлээд байна.

Олон улсын хууль эрхийн хэмжилзүйн байгууллагаас 2008 онд шинэчлэн гаргасан таксиметрийн OIML R-21 зөвлөмжийг орчуулах ажлыг техникч Д.Батзоригт, улсын шалгагч Б.Пүрэвтогтох, А.Галбаатар нар “Тээврийн хэрэгслийг хөдөлгөөнтэй үед нь жинлэх болон тэнхлэгт ачааллыг хэмжих зориулалттай автомат хэмжих хэрэгсэл” OIML R 134-1; OIML R 134-2 зөвлөмжийг, OIML R75-3 ”Дулааны тоолуур. 3 дугаар хэсэг: Туршилтын тайлангийн маягт” олон улсын зөвлөмжийг, улсын шалгагч Т.Батмэнд OIML R-60 “Ачааллын элементэд тавигдах хэмжил зүйн шаардлага” зөвлөмжийг, У.Дэлгэрбаяр “ISO 4064-1 Битүү шугам хоолой дахь зарцуулалтын тоолуур. Тодорхойлтууд” стандартыг тус тус орчуулан хяналтад шилжүүлээд байна.

Улсын шалгагч З.Мөнхбат удирдуулсан улсын шалгагч нарын MNS 3015-2014 “Шатахуун түгээгүүр. Шалгах арга хэрэгсэл” стандартыг шинэчлэн Хэмжилзүйн стандартын техникийн хорооны хурлаар оруулан хэлэлцүүлэн, батлуулсан бөгөөд .

“Алко-II хяналтын систем. Шалгах арга хэрэгсэл” стандартыг орчуулан Хэмжилзүйн стандартын техникийн хорооны хурлаар оруулан хэлэлцүүлэн, батлуулж, MNS 3015-97 “Шатахуун түгээгүүр. Шалгах арга хэрэгсэл” стандартыг дахин хянаж хэмжилзүйн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

#### **4. Албан бичгийн шийдвэрлэлт, санал гомдлын талаар:**

2014 оны эхний хагас жилд хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын холбогдолтой нийт 109 хүсэлтийг албан тоотыг хүлээн авч (ЦХХБЛабораторид – 16, МХХБЛабораторид – 43, ЭБХХБЛаборатоид- 35, ДДХХБЛабораторид – 15) 106 албан бичигт хариу өгч шийдвэрлэсэн байна. Албан бичгээр тавьсан 3 хүсэлт шийдвэрлэх шатандаа байна. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалттай холбоотой 450 гаруй шуурхай дуудлагыг утсаар хүлээн барагдуулан ажилласан байна.

Ахлах мэргэжилтэн П.Цэрэн-Очир Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шинжээчээр томилогдон “Сарэм Макина” ХХК-ийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийн бүрдэл болох хуванцар хоолойны диаметрийг хэмжиж дүгнэлт гарган тус шүүхэд хүргүүллээ.

Хэрэглэгч Э.Түвшинтунгалагаас 2014.02.18-нд, М.Аззаяагаас 2014.02.21-нд, Д.Нинагаас 2014.01.14-нд, СБД-н 5 хорооны иргэн Батсайханаас 2014.04.10-нд, БЗД-ийн 8-хорооны иргэн С.Баярсайханаас 2014.5.20-нд, Санзай хотхон СӨХ-ийн иргэдээс 2014.4.21-нд ирсэн хэмжих хэрэгслийн заалтын үнэн зөв байдал, загварын туршилт, баталгаажуулалтын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн шийдвэрлэж хариу өгсөн.

#### **5. Хэмжил зүйн хяналт шалгалтын талаар:**

СХЗГ ба МХЕГ-ын 2014 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 02-02/84 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар хотод автомашины жингээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн хэрэгжилт, худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгслийн загварын туршилт, баталгаажуулалт, ашиглалтын байдалд хэмжил зүйн хяналт шалгалтын ажлыг хийлээ.

Энэ хяналт шалгалтын ажлыг Стандартчилал, хэмжил зүйн газрын Механик хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын лаборатори хариуцсан ахлах мэргэжилтэн улсын байцаагч П.Цэрэн-Очир, хэмжүүрийн улсын шалгагч Батмэнд, Батсүх, Галбадрах нар НМХГ-ын хэмжилзүйн хяналтын улсын байцаагч нартай хамтран 2014 оны 3 дугаар сарын 26-наас 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Шалгалтанд “Нийтлэг үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ, “Алтан тариа” ХК, “Натур агро” ХК, “Мах маркет”, “Багануур” ХК, асфальт, бетон зуурмагийн “Рокмон”, “Оргил”, “Ремикон” ХХК, “Нийслэл өргөө”, “Ария”, “Премиум конкрет”, “Эрэл” ХХК, Багануур” ХК, “Дөл түшиг” төмөрлөгийн үйлдвэр зэрэг 19 аж ахуйн нэгж, 3 иргэний, ОХУ, БНСУ, БНХАУ, Япон улсад үйлдвэрлэсэн 30-150 тонны даацтай, механик болон электрон нийт 25 автомашины жинг хамрууллаа. Хяналт шалгалтаар:

1. автомашины суурин жингийн суурилуулалтын ажлыг мэргэжлийн бус байгууллага, хүмүүсээр гүйцэтгүүлсэн, эсвэл суурилуулсан аж ахуйн нэгжийн тухай мэдээлэл тодорхойгүй;
  2. жингүүдийг улсын ээлжит баталгаажуулалтад хамруулаагүй, алдаатай;
  3. ашиглагдаж байгаа жингүүдийн улсын баталгааны хугацаа дууссан, баталгаагүй хэмжих хэрэгслээр худалдаа, үйлчилгээ эрхэлж байсан;
  4. хэмжих хэрэгсэл баталгаажуулах гэрээг хэмжилзүйн байгууллагатай байгуулаагүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн байна.
- Хяналт шалгалтын явцад 8 жинг ээлжит баталгаажуулалтад хамруулан шалгалтанд хамрагдсан нийт аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, холбогдох ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нийт 9 аж ахуйн нэгж, иргэнд “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хуулийн дагуу 910 мянган төгрөгийн торгууль, 105 мянган төгрөгийн хууль бус орлого ногдуулж, бүрэн барагдуулав.

Илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 9 байгууллага, аж ахуйн нэгжид 27 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага, 2 байгууллагад /НХОГ, ЗТЯ/ албан бичиг хүргүүллээ.

“Гурвалжин” барилгын материалын захад борлуулж байгаа цементийн савалсан байдалд НМХГ-ын улсын байцаагчидтай хамтран хэмжил зүйн хяналт хийж 5 зөрчил илрүүлэн холбогдох арга хэмжээг авч шийдвэрлүүлсэн.

Газрын дарга Г.Гантөмөртэй хамт Өмнөговь аймагт байгалийн баялаг олборлож экспортод гаргаж байгаа “Энержи ресурс” ХХК, “Оюу толгой” ХК, “Эрдэнэс Таван толгой” ХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн зэс нүүр с олборлож, экспортлох үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа хүнд даацын автомашины жингийн баталгаажуулалт, ашиглалтын байдалд хэмжил зүйн хяналт хийсэн.

## **6. Ажлын эталон, түүний техникийн бэлэн байдлын талаар:**

ЦХХБЛ-ийн электрон тоолуурын баталгаажуулалтын ST9001D5 маягийн эталон төхөөрөмжийн аттестатчилал 2014 оны 05 сард хийлгэж гэрчилгээжүүлээ.

Лабораторийн эталон тоног төхөөрөмжийн нарийвчлалыг дээшлүүлэх, эталоны бааз суурийг бэхжүүлэх чиглэлээр гүйдлийн трансформатор шалгах шинээр авсан эталон төхөөрөмжийг авч ажилд оруулсан.

Улсын шалгагч нарт ашиглаж байгаа секундомерээ жил бүр өөрсдөө тогтмол ЦЭЛабораторид очиж шалгуулж байна.

ЭБХХБЛ-ийн явуулын лабораторын ажлын эталон, холбогдох хэмжих хэрэгсэлийн 2014 оны ээлжит шалгалт тохируулгад хамруулсан. Усны тоолуур шалгах EP-20 төхөөрөмжийг эталон мерник, жингүүд ээлжит шалгалт тохируулгад хамруулах ажил хийгдэж байгаа.

Засгийн газрын 2009 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн салбарт хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд температур, даралтын хэмжлийн ажлын эталон бий болсонтой холбогдуулан эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа даралт, температурын хэмжлийн төрлийн хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах бүрэн боломжтой болсон. Шинээр нийлүүлэгдсэн ажлын эталон хэмжих хэрэгслийн бүртгэлийг шинэчлэн гаргасан.

МХХБЛ-ийн эталон жин, туухай/20 кг-ы 99 ширхэг, 50 кг-ын 84 ширхэг/-г 2014 оны 3-р сард МЭЛабораторид өгч шалгалт тохируулгад хамруулсан. Хүч хатуулгын эталон багаж хэрэгслүүд ашиглалтанд орсон цагаасаа хойш буюу 2005 оноос хойш баталгаажигдаагүй байгаа.

Гадаад харьцуулалт дүйцүүлэлт, калибровкад хамруулах шаардлагатай гэсэн асуудлыг хэлтсийн даргад танилцуулж ирсэн бөгөөд жил бүрийн төсөв, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд оруулахаар санал тавьсан гэдэг боловч одоо болтол шийдэгдээгүй байна.

Таксиметрийн баталгаажуулалтын ажлыг эхлүүлэхэд бэлтгэн Улаанбаатар хотын Нийтийн тээврийн газар, НМХГ, “Такси үйлчилгээ эрхлэгчдийн холбоотой хамтран Улаанбаатар хотод такси үйлчилгээ эрхэлж байгаа 16 компанийн 600 гаруй таксиг тоолууржуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн “Такси үйлчилгээ эрхлэгчдийн холбоо”-той таксиметрийн баталгаажуулалтын талаар санал солилцож, газрын даргад танилцуулж, хамтарсан ярилцлага хийсэн.

## **7. Сургалт, сурталчилгааны талаар:**

СХЗГ-аас баталсан нэгдсэн сургалтын төлөвлөгөөний дагуу 2-р сард “Усны тоолуурын шалгагч, засварчин тохируулагч”, 3-р сард “Шатахуун түгээгүүрийн засварчин тохируулагч” бэлтгэх сургалт, 3-р сарын 03-аас 14-ны хооронд “Цахилгаан хэмжих хэрэгслийн засвар

тохируулгын ажилтны сургалт”, 05 дугаар сарын 05-наас Дулаан, даралтын хэмжлийн төрлөөр хэмжил зүйн ажилтныг мэргэшүүлэх сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулан ажилсан. Мөн Дархан, Увс, Өвөрхангай, Хэнтий Дундговь, Увс аймгийн СХХ-д шинээр ажилд орсон хүмүүсд улсын шалгагчийн эрх олгох сургалт, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн 3 хүмүүс эзэлхүүн, багтаамжийн хэмжлийн төрлөөр, Хэнтий Дундговь, Увс Төв аймгийн хүмүүст даралтын хэмжүүрийн улсын шалгагчийн эрх олгох сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. ЭБХХБЛ “Хяналтын систем-Алко, шалгах арга хэрэгсэл”, Усны тоолуурын техникийн шаардлага сэдвээр дотоод сургалт зохион байгууллаа.

Ахлах мэргэжилтэн П.Цэрэн-Очир нь ТВ-25 телевизийн асуудал дэвшүүлсэн “Монгол такси” нэвтрүүлэгт оролцон таксиметрийн баталгаажуулалтын өнөөгийн түвшин, цаашдын зорилтын талаар, ТВ-1, МН-25, “2-р суваг” зэрэг телевизүүдэд худалдааны жингийн баталгаажуулалт, зөрчлийн талаар, ахлах мэргэжилтэн Н.Мяасүрэн Монгол телевизд шатахуун түгээгүүрийн баталгаажуулалт, MNS телевизд усны тоолуурын баталгаажуулалтын талаар, А.Ганболд “Хэмжил ба дэлхий дахины эрчим хүчний тулгамдсан асуудлууд” сэдвээр Суваг 2 телевизийн шууд ярилцлагад ярилцлага өгсөн.

Түүнчлэн МХЕГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу Дархан-Уул аймагт болсон дэд бүтцийн улсын байгаагч нарын мэдлэг дээшлүүлэх үзүүлэх сургалтанд хичээл зааж дулаан, цахилгаан эзэлхүүн хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, орчин үеийн ухаалаг тоолуурын талаар MNB, ТВ9, Дарханы телевизүүдэд ярилцлага өгсөн.

Дэлхийн Хэмжил Зүйн өдрийн арга хэмжээнд улсын шалгагч Г.Хишигдэлгэр СХД 12-р сургуулийн хүүхдүүдэд усны тоолуурын талаар, Н.Мяасүрэн ХУД-ын бага сургуульд сургууль дээр Хэмжил зүйн ойлголт сэдвээр хичээл заасан.

Дэлхийн хэмжил зүйн өдөрт зориулан “Хэмжил ба дулааны эрчим хүчний хэмнэл” “Цахилгаан эрчим хүчний чадлн хэмжилд тулгамдаж буй асуудлууд”, “Цахилгаан эрчим хүчний тоолуурын тухай” сэдвээр материал бэлтгэн Стандарт, хэмжил зүйн сэтгүүлд нийтлүүлсэн. Түүнчлэн “Зууны мэдээ” сонинтой хамтран ажиллах гэрээний хүрээнд 5 дугаар сарын 27-ны өдрийн дугаарт Жи-Эйч-Эл ХХК-тай хамтран “Хэрэглэгч та ашиглаж байгаа хэмжих хэрэгсэлээ үнэн зөв зааж байгаад эргэлзэж байвал бидэнд хандана уу” сэдвийн дор А4 хэмжээтэй мэдээ нийтлүүллээ.

**6. Хэмжил зүйн тусгай зөвшөөрөл, хэмжих хэрэгслийн загварын туршилтын талаар:**

Тайлангийн хугацаанд ХХШБХ-ийн ажилтнуудын орж ажилласан ажлын хэсгийн судалгаа.

Тусгай зөвшөөрөл

№	ААНБ-ын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл	Ажлын хэсэгт ажилласан ажилтны нэр	Шийдвэрлэсэн хурал, огноо
---	-------------	--------------------------	------------------------------------	---------------------------

1	“Электрон түлхүүр” ХХК	Суурилуулалт, засвар тохируулга	П.Цэрэн-Очир, Н.Мяасүрэн	
2	“НИК Петровис”ХХК	Суурилуулалт, засвар тохируулга	У.Дэлгэрбаяр Д.Энхмаа	
3	”Дорнот НАА ” ОНӨҮГ	Суурилуулалт, засвар тохируулга	З.Мөнхбат	
4	”Пронхит ”ХХК	Суурилуулалт, засвар тохируулга	З.Мөнхбат	
5	Архангай ”Ундарга ”ХХК	Суурилуулалт, засвар тохируулга	Г.Хишигдэлгэр	
6	“Хэмжих хэрэгсэл” ХХК	Суурилуулалт, засвар тохируулга, худалдаа	П.Цэрэн-Очир	
7	Ультра хит ХХК	Уурын тоолуур суурилуулах	Ц.Одонтуяа	2013 оны 02 дугаар сарын ХЗЗөвлөл
8	Ану сервис ХХК	Дулааны тоолуур суурилуулах	Ц.Одонтуяа	2015 оны 05 дугаар сарын ХЗЗөвлөл
9	Ирмүүн эхлэл ХХК	Дулааны тоолуур суурилуулах, худалдах	Ц.Одонтуяа	2013 оны 06 дугаар сарын ХЗЗөвлөл
10	Энержи стандарт ХХК	Уурын тоолуур суурилуулах	А.Ганболд Б.Чинбат	2013 оны 06 дугаар сарын ХЗЗөвлөл

#### Загварын туршилт

№	ААНБ-ын нэр	Загвар туршилтад орсон хэмжих хэрэгсэл	Ажлын хэсэгт ажилласан ажилтны нэр	Шийдвэрлэсэн хурал, огноо
1	“Энержи тех прогресс” компаний	Меркурий-200.6, Меркурий-230 маягийн электрон тоолуур	Д.Ням-Очир	
2	“Алтай-Улиастай ЭХСистем” ТӨХК-	нэг ба гурван фазын DDS238, DTS238 загварын тоолуур	Д.Ням-Очир	
3	“Цацрах цог” ХХК-	нэг ба гурван фазын DDS976, DTS976	Д.Ням-Очир	

		загварын тоолуурууд		
4	“УБЦТС” ТӨХК	DDS26D, DDSY23S загварын нэг фазын электрон, DTSY23S, DTSY23S-VT загварын гурван фазын электрон	Д.Ням-Очир	
5	“Геомин групп” ХХК	CL730S1 загварын гурван фазын тоолуур	Д.Ням-Очир	
6	“BTN технологи” ХХК-	нэг фазын HEBA 1041SO электрон тоолуур	Д.Ням-Очир	
7	“Индустрал газ депо Монголиа”	Хий жигнэх зориулалтын электрон жин	Т.Батмэнд	
8	Молонгоо” ХХК	Усны тоолуур	М.Гомборагчаа	
9	” Тот ком сервис” ХХК	Усны тоолуур	З.Мөнхбат	
10	“Гор газ” ХХК	Хийн тоолуур	Б.Байгаль	
11	“Эко могул”	TCS–300 жинд	Т.Батмэнд	
12	“Жин хэмжүүр” ХХК	BW-1, PB жин	А.Галбаатар	
13	“Хэмжих хэрэгсэл” ХХК	SCS-150	Б.Пүрэвтогтох	
14	Альянс Тех ХХК	ULTRA SONIC FLOW METER-USM-S загварын дулааны тоолуур	Б.Чинбат Ц.Одонтуяа	Загварын туршилтад тэнцээгүй
15	Альянс Тех ХХК	ВЗЛЕТ TCP-M загварын хэт авианы нийлмэл дулааны тоолуур	А.Ганболд Ц.Одонтуяа	2013 оны 05 дугаар сарын ХЗЗөвлөл
16	Үлэмж тэлэхү	Евро альфа, А1140, А1800 загварын тоолуурууд сунгах	Д.Ням-Очир	
17	Элмико ХХК	10кА GSWS12, GSES12D загварын трансформатор	Д.Ням-Очир	
18	Динлау ХХК	DDS666, DTS634, DDSI666, DDSF666	Д.Ням-Очир	
19	Жин хэмжүүр ХХК	DDS44, DTS51 загварын цахилгаан тоолуур	Д.Ням-Очир	

		шинээр		
20	Ди-Ю-Би-Би ХХК	DEXEN загварын гүйдлийн трансформатор	Д.Ням-Очир	
21	Электрон түлхүүр ХХК	ЛО-1000 загварын цахилгаан тоолуурууд	Д.Ням-Очир	

**7. Бусад ажлын талаар:**

Снукер билльяардын тэмцээнд хамт олноороо амжилттай оролцож тэргүүн байр, сагсан бөмбөгийн тэмцээнд эр, эм багаараа 2 дугаар байр эзлэллээ.

Мөн MASM-KRISS-ийн нөхөрсөн тэмцээнд болон газраас зохиогдож байгаа олон нийтийн ажилд манай хамт олон амжилттай оролцож ирсэн.

ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ШАЛГАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХЭЛТЭС

